

М.Гантуяа

Шашин судлалын тэнхмийн
багш, доктор, дэд профессор

**Буддын философийн асуудлууд ба
К.Ясперсийн эрэгцүүлэл**

Товч утга: Цаг хугацаа, орон зайн алслалд байгаа философийн үзэл баримтлалыг эдүгээчлэн, өөриймчлөн сэтгэх нь философийн эх сурвалж судлалын дараагийн шат, гүн нарийн түвшний ажил болох учраас өрнө, дорнын философийг өнгөрсөн ирээдүй үе болгон, орон зайн ялгаатайгаар авч үзэх ойлгохуйн эхний шат байхыг үгүйсгэх аргагүй. Гэсэн ч байгаа хүчин чадалдаа тохируулж буддын философийг эдүгээчлэн ойлгож, орчин үеийн өрнийн философитой нэгдэн нийлэх учир тавилан буй эсэхийг эргэцүүлэхэд илүүдэх юун. Энд буддын философийн дэвшүүлсэн зарим асуудлуудыг буддизмд болон орчин үеийн экзистенциалист философич К.Ясперсын үзэл онолд хэрхэн шийдвэрлэсэн арга зүйг зэрэгцүүлэн үзэх оролдлого хийсэн юм.

Түлхүүр үг: compositional factor, consciousness, feeling, perfection, wisdom.

Буддын философи бол хүн төрөлхтний философи сэтгэлгээний өнгөрсөн үе, түүний хөндөж тавьсан асуудлууд нь хэдийнээ үе улирсан хэмээн үзэхийн зэрэгцээ орчин үеийн өрнийн философийг шүтэн дээдлэх хандлага өнөө үеийн манай монголын философичдын дунд бий. Энэ нь ч бодит шалтгаантай юм. Харипцаа холбоо, ойлголт мэдлэггүйгээр философийн ямар ч эргэцүүлэл байх боломжгүй. Өнөө үеийн монголын төрийн албан ёсны бичиг болох кирилл үсгээр монгол хэлнээ хөрвүүлэгдсэн буддын болон өрнийн философийн сурвалжийг тоолбол хуруу дарам цөөхөн билээ. Харин төвдөөр болон уйгаржингаар бичсэн буддын философийн эх сурвалж, эсвэл англи, герман гэхээсээ илүүтэй орос орчуулга, дам судалгаанаас төрсөн өрнийн философийн талаархи мэдлэгтээ тулгуурлан бичсэн судлаачдын бүтээл, өгүүлэл арвин буй. Буддын болон өрнийн философийн эх сурвалж дээр тулгуурлан ижил төрлийн асуудлыг шийдвэрлэсэн ялгааг гаргахыг оролдъё.

Буддын философийн хамгийн гол дөрвөн асуудал буй: Зовлон, зовлонгийн шалтгаан, зовлонгоос ангижирсан амарлингуй нирваан, зовлонгоос ангижрах арга замын тухай гэсэн дөрвөн асуудал болой. Хүн амьдралынхаа туршид өөрчлөгдөн хувьсах ертөнц, өөрийн бие сэтгэлийн тогтворгүй байдлын шуурганд туугдан төөрч, өчүүхэн төдий ч амсхийж чадалгүй байсаар нэгэн

насыг бардаг. Хүний сэтгэлд өөрт нь байх атаа жетөө, уйтгар гуниг, хорсол занал, шунал тачьяал, уур хилэн, омог дээрэнгүй, увайгүй үлбэгэр авир зан, нүгэл хилэнц – энэ бүхэн нь тэрхүү төөрөгдлийн шалтгаан болно. Харин сэтгэлээсээ тэр бүх хир буртаг, нисваанисыг таягдан хаяж, нүгэл хилэнцийг тэвчвээс зовлонгийн далайгаас аврагдан сэтгэлийн гүн тайтгарлыг амсах болно. Тэрхүү тайтгарал бол хүнээс ангид байдаг бурхан тэнгэрийн чанар бус, харин хүний сэтгэлд өөрт нь байдаг далд нууц мөн чанар юм хэмээн буддын философид номлодог. Хүний сэтгэлийн далд нууц чанарын тухай асуудал нь үнэндээ орчин үеийн өрнийн философичдын эргэцүүлэл бодролын төвд байгаа нэгэн чухал асуудал мөн билээ. Ялангуяа экзистенциалист философичид энэ асуудлыг тал бүрээс, олон янзаар тайлбарлан номлодог. Тэдгээрийн нэгийг энд төлөөлүүлэн авч үзье.

Орчин үеийн өрнийн философийн нэгэн том төлөөлөгч, германы нэрт сэтгэгч К.Ясперс (1883-1969) сэтгэл мэдрэлийн эмчээс сэтгэл судлаач, улмаар экзистенциалист философич болжээ. Түүний анхны том бүтээл нь аливаа өвчинд зөвхөн биеийн байдал төдийгүй сэтгэлийн байдал түүнээс дутахгүй нөлөөлдгийг гаргасан "Сэтгэлзүйн түгээмэл эмгэг судлал" (1913) хэмээх зохиол мөн боловч "Ертөнцийг үзэх үзлийн сэтгэлзүй" (1919) хэмээх олон жилийн хөдөлмөрийн үр дүн болсон бүтээлээрээ философийн салбарт алдаршсан юм. Энэ зохиолоо хэвлүүлснийхээ дараахан Ясперс Гейдельбергийн Их сургуулийн философийн багш болжээ. Ясперсын философийн үзэл санаа бүрэлдэхэд Гуссерлийн эхэн үеийн бүтээлүүд, В.Дильтейн "ойллогч философи", Ф.Ницшегийн уран бүтээлүүд, мөн М.Веберийн улс төр-философийн судалгааны арга зүйн зарчмууд нөлөөлсөн байна. Ялангуяа Веберийн үнэлэмжийг хатуу ангилах зарчим, судалгааны шинжлэх ухаанч байр суурь, философийг бусад бүх шинжлэх ухаанаас оюун санааны онцгой далд үзэгдэл гэх үзлийг нь Ясперс илүүтэй дээдэлж байв.

Харин түүний үед Гейдельбергийн Их сургуулийн Философийн тэнхмийн эрхлэгч байсан Г.Риккерт экзистенциалист философи, ялангуяа философийн судлах зүйл болон арга зүйг сэтгэлзүйн хүрээнд авч үзэх Ясперсын хандлагыг хатуу эсэргүүцэж байжээ. Философийн экзистенциалист сэтгэлгээг философийн уламжлалт системээс гарган, биеэ даасан систем болгох зорилгоор арваад жил хөдөлмөрлөж бүтээсэн Ясперсын "Философи" хэмээх зохиол нь түүнийг Германы нэрт философич болгосон байна.

К.Ясперс еврей эхнэртэй байсны улмаас фашист Германы үед иргэний бүх эрхээ хасуулж, нууц байдалд ажиллан, "Үнэний тухай", "Нүглээ наминчлах тухай

асуудал”, “Ницше ба христос шашин”, “Европын оюун санааны тухай”, “Түүхийн эх сурвалж ба түүний зорилго”, “Философийн итгэл үнэмшил” зэрэг бүтээлүүддээ аж үйлдвэржсэн нийгэмд европын соёл иргэншил, европын хүмүүсийн оюун санааны чиг баримжаа ямар байх талаар өөрийн үзэл бодлоо бичсэн боловч зөвхөн дэлхийн хоёрдугаар дайны дараагаар л тэдгээр нь хэвлэгдэн гарсан юм. Харин дайн дууссанаас хойш Гейдельбергийн болон Базелийн Их сургуульд дахин багшлах болж, “Бидний ирээдүй ба Гёте”, “Манай эрин үеийн оюун ухаан ба түүний эсрэг оюун ухаан”, “Шинэ хүмүүнлэг үзлийн нөхцөл боломжийн тухай”, “ХБНГУ хаашаа явж байна вэ” зэрэг бүтээлүүддээ ХХ зууны тоталитар нийгмийн аюул заналаас хүн төрөлхтнийг хэрхэн авран хамгаалах тухай үзэл санаагаа илэрхийлсэн байдаг.

Ясперс ХХ зууны хүмүүс утга учиртай амьдралын чиг баримжаагаа шашин, сүсэг бишрэлтэйгээ хамт алдсаныг шүүмжлэн, экзистенциалист философи энэхүү алдагдлыг нөхөх чадвартай хэмээн үзжээ. Тэрээр нэгэн зарчмаар сэтгэлгээнийхээ агуулгыг гаргаж ирдэг уламжлалт философичлолын оронд чөлөөт сэтгэлгээнд хөтлөгдсөн шинэ философичлолыг санал болгосон юм. Ясперс хатуу системтэй гаргалгаа хийхээсээ илүү тодорхой сэдвээр ангилж асуудал дэвшүүлэхийг гол болгосон байна. Гэхдээ бүх асуудал дотроос хүний ахуй, нийгэм-түүхийн асуудлыг хамгийн гол асуудлаа болгосон юм. Хүний ахуйг тодорхойлох хамгийн гол зүйл бол *тохироо* хэмээн тэрээр үзжээ.

Хүний хувь заяаны эмзэг асуудал, баяр жаргал, итгэл найдвар, зовлон гуниг, нүгэл хилэнц болон нийгмийн хөгжлийн онцгой үйл явдал нь “цаг хугацаа”, “эрин үеийн” агуулга байх ба давтагдашгүй цор ганц тохироогоор нөхцөлдөнө. Үйл явдал бүхэн нэг нь нөгөөгөөсөө тохироогоороо ялгарна. Хүний оршихуй нь цаг хугацаа, түүхэн чанараар илрэнэ гэж Ясперс үзсэн байна. “Өнгөрсөн үе нь бидний ой санамжинд хэсэг бусаг байдлаар агуулагдана, ирээдүй үе нь харанхуй бүрхэг болой. Зөвхөн одоо цаг л туяаран гийж чадна. Бид бүхлээрээ түүн дотор л байгаа шүү дээ. Гэвч чухам одоо цаг л нэвтрэшгүй болой, учир нь одоо цагийн үндсийг тавьсан өнгөрснийг, мөн одоо цагийг өөртөө нуун далдалж байгаа ирээдүйг бүхлээр нь мэдсэн цагт л одоо цаг тодорхой болно. Бид өөрсдийн үеийнхээ тохироог ухамсарлах гэж тэмүүлж байна. Гэвч энэ тохироо нь боловсорсныхоо дараа л нүдэнд ил болох далд нууц боломжийг эзэмдэнэ”¹ хэмээн тэрээр бичсэн байдаг. Ясперс өнгөрсөн, одоо, ирээдүй цагийг нэгэн

¹ Карл Ясперс. Смысл и назначение истории. Москва 1991. стр. 141

бүхэл гэж үзээд одоо цагийг өнгөрсөн ба ирээдүйгээс салган ухамсарлах боломжгүйг илэрхийлжээ.

Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн асуудлыг буддын философид, ялангуяа түүний дээд оргил нь болох хоосон чанарын онолд үүнтэй адилаар нэгдэлд нь авч үзсэн байх боловч одоо цагийг ч тодорхойлж болохгүй гэсэн байр суурь барьснаараа Ясперсын дээрхи үзлээс ялгарч байгаа юм. Тухайлбал, Нагаржунагийн “Хоосон чанарын далан шүлэгт” зохиолд: “гурван цаг нь орших үгүй, янагш чанагшаас бүтсэн хийгээд өөрөө эс бүтсний тул, бод үгүйн тул, солихын тул, буй бус адхагийн төдийхөн”² гэжээ. “Энэ нь нэгдүгээрт, цагт тарах эвдрэх үгүй, иймд орших үгүй, иймээс ч эс бүтсэн, хоёрдугаарт, гурван цагийг ... нэгд нь шүтүүлэн нөгөө хоёрыг бүтээдэг, иймээс бие биедээ барилдсанаас бус, үнэн чанараар бүтсэн бус, гуравдугаарт, нөгцсөнд нэрийдэж ирээдүй, ирээдүйд нэрийдэж нөгцсөн (өнгөрсөн) гэж бие биед нь солиж өгүүлэхээс бус, уг чанартаа гурван зүйл биш, иймд эс бүтсэн, дөрөвдүгээрт, бод бүтвээс цаг ч бүтсэн болно, гэтэл бодыг үнэхээр бүтээгүй гэдгийг ухьд гаргасан, иймээс цаг бүтсэн бус гэж дүгнэжээ Ийнхүү хэд хэдэн үндэслэлээр Нагаржуна цаг үнэхээр бүтсэн бус, хоосон чанартай хэмээн нотлосон юм”³. Гэхдээ Нагаржуна хоосон чанарын онолын үүднээс асуудлыг боловсруулахдаа хатуу логик зарчимд тулгуурласан байхад Ясперс амьдралын үйл явцыг өрнөл дунд нь, сэтгэлгээний чөлөөт совингоор илэрхийлсэн ялгаа ажиглагдана.

Буддын философид хүний мөн чанарыг “таван цогц” хэмээх таван гол талаас тайлбарладаг. Эхний *дүрсийн цогцын* хүрээнд тайлбарлавал, хүмүүс нүд, чих, хамар, хэл, бие гэсэн таван эрхтнээрээ ертөнцийн юмс үзэгдлийн дүрс, дуу, үнэр, амт, хүртхүйн таван шинжийг л илрүүлж чадна. Харин эдгээрээс өөр шинж чанар юмс үзэгдэлд буй эсэхийг хүн мэдэж чадахгүй, учир нь таван эрхтнээс өөр мэдрэхүйн эрхтэн хүнд байхгүй. Иймээс дүрсийн цогц нь зөвхөн хүний мэдрэхүйн ертөнцийг л илэрхийлэхээс бус, бүх ертөнцийн илэрхийлэл болж чадахгүй. Хоёр дахь, *сэрэхүйн цогцын* хүрээнд тайлбарлавал, хүмүүс ертөнцийн юм үзэгдлийн тухай ойлгохдоо, тэдгээр нь өөрт нь хэр таалагдаж байгааг шалгуур болгон үнэлэмжийн байр сууринаас ханддаг. Жишээ нь амт, үнэрийн тухай ярихдаа тэр нь хүмүүст аятай таатай байж чадах уу, үгүй юу гэдгээс асуудалд ханддаг. Иймээс хүмүүсийн ойлголт нь объектив бодит байдлыг цэврээр нь илэрхийлдэггүй, ямагт субъектив шинжтэй болой. Гуравт, *хуран мэдэхүйн цогцын* хүрээнд тайлбарлавал, хүмүүс харсан мэдэрсэн юм

² Монгол Данжуур, 105 дугаар боть, х.37, доорд.

³ Г. Лувсанцэрэн. Нагаржунагийн философийн үзэл. УБ. 1981. х.71.

үзэгдлээ өөр бусад юм үзэгдлээс ялган харьцуулж илэрхийлдэг бөгөөд тухайн юм үзэгдлийн өөрийн гэсэн өвөрмөц шинж чанарыг нь тодорхойлох замаар мэдлэг үүсгэдэг. Гэвч энэ мэдлэг нь ертөнцийн түгээмэл харилцаа холбоо, шүтэн барилдлагын уялдаанаас тухайн юм үзэгдлээ таслан салгаж илэрхийлдэг учир туйлын үнэн байж чадахгүй. Дөрөвт, *хуран үйлдхүйн цогцын* хүрээнд тайлбарлавал, хүний ертөнцийг илэрхийлэхэд тухайн хүний уг зан чанар, төрөлхийн авир байдал, мөн байгалийн төрөх, өсөх, өтлөх үйл явц, нийгмийн хөгжлийн хууль зүй тогтол зэрэг хүчин зүйлүүдийг хамааруулдаг. Ийнхүү хүний ертөнц гэдэг бол тухайн хувь хүний ертөнц мөн болох юм. Тавд, *тийн мэдэхүйн цогцын* хүрээнд тайлбарлавал, хүн ертөнцийн юм үзэгдлийг ойлгохдоо сэтгэн бодох, ухамсарлан ухварлах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүний үр дүнд өөрийн гэсэн ертөнцийг үзэх үзлийг бүрдүүлдэг байна.

Эндээс дээр дурдсан Ясперсын тохирооны тухай үзэл нь буддын философи дахь хуран мэдэхүй, тухайлбал төгөлдөр бус хуран мэдэхүйн асуудалд хамаатай болохыг харж болно. Хувь хүний амьдрал, хувь зохиол нь түүний амьдарч буй цаг хугацаа, нийгмийн хөгжлийн чиг хандлагаас шалтгаалдаг болохыг тодорхойлсноороо адил боловч буддын философид асуудлын аль нэг талыг дангаар нь авч үздэггүй, таван цогцын хүрээнд хамтруулан нэгэн бүхэл болгож тавьдаг учир тохироо нь дангаараа хүний мөн чанарыг илэрхийлж чадахгүй. Харин Ясперсын хувьд тохироо бол хүний мөн чанарыг илэрхийлэх гол ойлголт болно. Буддын философид “хэрвээ дүрсэд явбаас бэлгэд явсан болой. Хэрвээ дүрсний бэлгэд явбаас бэлгэд явсан болой. Хэрвээ дүрс бэлгэ болой хэмээн явбаас бэлгэд явсан болой. Хэрвээ дүрсний төрөхүйд явбаас бэлгэд явсан болой. Хэрвээ дүрсний түрдэхүйд явбаас бэлгэд явсан болой. Хэрвээ дүрсний эвдрэхүйд явбаас бэлгэд явсан болой. Хэрвээ дүрс хоосон болой хэмээн явбаас бэлгэд явсан болой. Би явбаа хэмээн явбаас бэлгэд явсан болой. Бм бодисатва болой хэмээн явбаас бэлгэд явсан болой. Би бодисатва болой хэмээн явбаас бэлгэд явсан болой. Би бодисатва болой хэмээн бөгөөс тийн эвдрэхүйд явсан болой. Түүнчлэнхүү хэрвээ сэрэхүй, сэтгэхүй, үйлдэхүй нүгүүд хийгээд хэрвээ тийн мэдэхүйд явбаас бэлгэд явсан болой”⁴ хэмээн үздэг. Энэ нь бие хүний амьдрал, ертөнцийн аливаа тал шинжийг ямар нэг тодорхойлох чанартай хэмээн үзэх нь түгээмэл харилцаанаас

⁴ Найман мянган Их хөлгөн судар оршивой. Төвд, монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлсэн

Г.Чанцал, Л.Дуламсүрэн. Адмон хэвлэх үйлдвэр. х. 12.

салган тусгаарласан үзэл болохыг заасан хэрэг юм. Тухайлбал, таван цогцын нэг болох дүрсийг төрсөн, түрдсэн, эвдэрсэн, хоосон, “Би” хэмээн амин хувиа баримталсан, бүх төрөлхнийг бодсон бодь сэтгэлийг барьсан г.м. тодорхойлолтын алинаар ч тодорхойлсон хязгаарлагдмал, өрөөсгөл тодорхойлолт гарах болно. Үүнтэй адилаар бусад цогцыг ч тодорхойлж болохгүй юм. Ингэхлээр Ясперсын “тохироо” нь өрөөсгөл тодорхойлолт төрүүлэх нэгэн сэдэв болой.

Ертөнцөд тодорхойлон баримтлах нэгээхэн ч юм үзэгдэл байхгүй хэмээн гутранги гэмээр үзлийг дэвшүүлэхийн зэрэгцээ хүн ертөнцийг үнэн мөнөөр нь ойлгон танин барихын тулд таван цогцын хүрээнээс ангижрах тухай асуудлыг буддын философид тавьсан нь хүмүүст итгэл найдвар төрүүлсэн өөдрөг баримтлал мөн юм. Ингэснээр сэтгэлийн далд мөн чанарыг илрүүлэх тухай яригдана.

Хүн бүрт субъектив чинад далд чанар байна гэдгийг Ясперс эмч байхдаа л мэдэрчээ. Түүний үзлээр эмч хүн өвчтөнтэй судалгааны объекттай харьцаж байгаа судлаач хүний ёсоор хандахаас биш, түүний сэтгэл зүрх рүү нь нэвтэрдэггүй, байнга зай барьж, хэзээ хэзээгүй өвчтнөөсөө харилцаагаа таслахад бэлэн байдаг. Харин өвчтөнтэйгээ хувь хүнийх нь ёсоор хандаж, сэтгэлийн гүн дотор нь нэвтэрч, оршихуйн экзистенциал харилцаа үүсгэж чадвал сая өвчнийг нь эдгээх боломжтой болно. Ийм харилцаа зөвхөн эмч өвчтний хооронд төдийгүй нэг шашинтан, нэг үндэстэн, нэг гэр бүл, судалгааны бүлэг, философийн нэг дугуйлангийнхны хооронд үүсвэл өгөөжтэй үр дүнд хүрч болно. Хүмүүсийн өөрийн ухамсар, дотоод “Би”-гийн амьдрал өсөх тусам харилцан ойлголцол, үнэнч нөхөрлөл, чин шударга байдал алдагддаг байна. “Хүн гэсэн үзэгдлийн бүх олон янз байдлын хүрээнд хамгийн чухал нь хүмүүс нэг нэгэндээ учир холбогдолтой байдаг явдал юм. Тэд уулзалдаж байгаа газар бүрд нэг нэгнийгээ сонирхож, нэг нэгэндээ дургүйцлээ юмуу, талархалтай байгаагаа мэдэрч, нэг нэгээсээ суралцаж, туршлагаа солилцдог. Хүмүүс уулзалдснаар өөрийгөө өөр байдлаар таних шиг, энэ бол өөр хүн гэж хүлээн зөвшөөрдөг өөр хүнд сөрж зогсноороо өөртөө тулгуурлах оролдлого хийх мэт болно. Энэхүү уулзалтад хүн өөрөө ямар ч онцлогтой байлаа гэсэн үнэндээ түүнд байхгүй бөгөөд түүнийг үл анзаарам удирдаж байгааг ч тэрээр мэдэхгүй, мөн агшин зуурд түүнийг болон бусад бүх хүмүүсийг урмаар бялхуулж байгаа нөгөөх л нэгдмэл дотор бусад бүх хүмүүстэй ерөнхий чанартай болохоо мэддэг. Энэ талаасаа “хүн” гэдэг үзэгдэл нь өөрийн бүх түүхэн олон янз байдлаараа

нэгдмэл рүү хандсан хөдөлгөөн мөн, энэ нь ерөнхий гарал үүслийн үр дагавар ч байж болно, ямар ч атугай, энэ бол өөрийн бүх гүн мөн чанараа аль нэг олонлогийн тархай бутархай байдалд илрүүлдэг оршихуй биш билээ”⁵.

Ясперсын үзлээр хувь хүн бүхэн бүхэл нэгдмэл амьдралын нэгэн агшин байдаг. Ард түмэн, үндэстэн, төр гэх зэрэг нь хувь хүн оршин байх байр орон, утга учир нь юм. Хувь хүн бүхэн тэрхүү бүхэл бүтэн зүйл дотор өөрийн гэсэн байр суурьтай, учир утгатай болохоо мэдэрдэг. Экзистенциалист философи нь “Би”-гийн түвшнийг өсгөлгүйгээр, хувь хүний гүн дотоод цөм болох оршихуй буюу экзистенцийг мэдрүүлэх үүрэгтэй болой.

Буддын философид Би-г дарж, чинад билиг, сэтгэлийн гүн мөн чанар, туйлын амарлингуй байдалд хүрэхийн тулд зөвхөн өөрийн сэтгэлийг ариусгахыг эхэндээ гол болгох боловч энэ нь жинхэнэ мөн чанартай зохицдоггүй хэмээн бодьсэтгэлийг бүрдүүлэх асуудлыг дэвшүүлэн тавьсан байна. Хүн бол бүхий л нэгдмэл ертөнцийн нэгэн өчүүхэн хэсэг, гэхдээ бүх ертөнцийн түгээмэл уялдаа холбооны зангилаа хэсэг учраас тэрхүү уялдаанаас хувь хүнийг салган амарлиулах боломж байхгүй гэж үзнэ. Иймээс хүний дотоод гүн мөн чанарт бүх төрөлхтнийг төлөөлөх бодьсэтгэл нуугдан байдаг. Бодьсэтгэл бол хувиа бодсон аминч сэтгэлийн эсрэг бүх төрөлхтнийг бодсон түгээмэл сэтгэл юм.

“Оёоргүй орчлонгийн түмэн зовлонгоос гэтлэх болоод

Олон амьтныг аюулаас аврахыг хүсэх ба

Түмэн амгалан буман жаргалыг эдлэхийг горилвоос л

Тэнсэлгүй боди сэтгэл ямагтыг хэзээд бүү орхисугай”⁶ хэмээн зовлон бэрхшээл, зөрчил тэмцэл, уйтгар гуниг, хорсол заналаас гэтлэх нь зөвхөн хувь хүний сэтгэлийн тайтгарлын асуудал биш, бүх төрөлхтний түгээмэл асуудал болохыг заасан буй. Энд үзэл санаагаа илэрхийлэх уран сайхны аргыг хэрэглэсэн нь ёс суртахууны нийтэч, эвсэг үзлийг итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн байр сууринаас тавьсантай холбоотой юм.

Хүмүүс нэг нэгнийхээ сэтгэлийн гүн рүү нэвтрэх асуудлыг тавихдаа Ясперс буддын философид бодьсэтгэлийн асуудлыг тавьсантай адил ёс суртахууны түгээмэл чанарын үүднээс бус, харин шинжлэх ухааны судалгааны аргазүйн үүднээс ханджээ. “Оршихуйн бүхэллэг чанар боловсроход хүн төгсгөлдөө хүрдэггүй учраас тэрээр оршихуйн дээгүүр нисэн өнгөрч өөрийн ахуйн түгээмэл

⁵ К.Ясперс. Түүхийн эх сурвалж ба түүний зорилго. (хэсэгчлэл). Орчуулсан М.Гантуяа

Эрх чөлөө ба философи. VII. УБ 2000. х. 2

⁶ Шантидэва. Бодисадын явдалд орохуй. Төвд хэлнээс орчуулсан Т.Булган. УБ 1998. х. 30

дүрээр харилцааны итгэлийг, хоёр дахь ертөнцөө, оюун санааны ертөнцөө олж орон зайд байрладаг юм. Үнэндээ, тэрээр оюунлаг ахуй болох хувьдаа оршихуйн бодит байдалтайгаа холбоотой байх боловч нислэгийнхээ үеэр түүний хүрээнээс гарч, бодит байдлаас агшин зуурд ангижирч, оюун санааны бүтээлд ахуй болон хувирч бодит байдалдаа эргэн ирнэ”⁷.

Ясперсын үзлээр хүний экзистенц гэдэг бол шинжлэх ухааны судалгааны объект болдоггүй, философийн бодролд өртдөггүй туйлын чөлөөт зүйл мөн. Хүн эсвэл судалгааны объект болдог, эсвэл эрх чөлөөт төрөлхтөн болно. “Хүн бол судалгааны авч үзэх асуудал болох талаасаа болон эрх чөлөө болох талаасаа зарчмын ялгаатай хоёр өөр эх сурвалж юм. Эхнийх нь мэдлэгийн агуулга, хоёр дахь нь бидний итгэл үнэмшлийн үндсэн шугам юм. Гэхдээ эрх чөлөөг мэдлэгийн агуулга болон судалгааны авч үзэх асуудал болгон хувиргавал тэр дороо л нэгэн онцгой мухар сүсэг үүснэ”⁸. Сэтгэл судлал, хүн судлал, нийгэм судлал, улс төр судлал зэрэг шинжлэх ухааны салбаруудад хүнийг эрх чөлөөт байдлаас нь буюу экзистенцээс нь ангид салгаж судалдаг. Хүний экзистенц нь байгаль, нийгэм, ёс суртахууны имманент хүрээнээс ангид чинад зүйл болой. Хүний амьдрал хувь заяатай салшгүй холбоотой тэрхүү чинад оршихуйн бодит болохыг хүлээн зөвшөөрдөг цорын ганц ухамсар нь сүсэг бишрэл юм. Байгаль, нийгэм, ёс суртахууны зайлшгүй биш, харин хувь хүний экзистенциал шинж зайлшгүй ноёрхдог чинад оршихуйг оюун ухаанаар танин мэдэхгүй. Гэвч ахуйн эх булаг болох, мэдрэхүй, сэтгэл хөдлөл, сохор тачьяал, зөн совин, дур зоргод тулгуурлах экзистенцийг оюун ухаанаар жолоодохгүй бол харалган хүчирхийлэлд автагдана гэж Ясперс үзжээ..

Буддын философийн ёсоор хүний сэтгэлийн чинад далд мөн чанар болох *билиг* нь зөвхөн түгээмэл харилцаа холбоо, шүтэн барилдлагыг ухаарсан ухаарал төдийгүй, сэтгэлийн хиргүй ариун байдал юм. Иймээс буддын сургаалд хэрхэн сэтгэлийн хирийг ариутгах арга зам, мөрийн асуудлыг авч үздэг юм. Уур хилэн, шунал тачьяал, атаа жетөө, хорсол занал, уйтгар гуниг зэрэг нь бүгд сэтгэлийн хир буртаг гэж тооцогдох бөгөөд буддын философид найман түм дөрвөн мянган нисваанисыг дарах тухай асуудал тавигддаг нь үнэн хэрэгтээ сэтгэлзүйн 8400 төлөв байдлыг судлан гаргасан хэрэг болно. Гэхдээ энэ тоонд тогтсон хязгаар байхгүй, хэн ямар байр суурь, тал чиглэлээс хандана, тэр бүр өөр өөрийн гэсэн тоон хязгаарыг тогтоодог. Өөрөөр хэлбэл, нисваанисын тоо

⁷ Карл Ясперс. Смысл и назначение истории. Москва 1991. стр. 357.

⁸ мөн тэнд

ямагт харьцангуй болой. “Найман түмэн номын цогцууд алимадыг Чадагч бээр номлосон. Тэдгээрийн үг буй нэр тэдгээр нь, дүрс хийгээд хуран үйлдхүүнүүдэд хурьюу. Заримууд шастарын хэмжээ хэмээн өгүүльюү. Цогц тэргүүтэн нэжгээд нэжгээд үг буй. Эдлэхүйнүүдийн ерөндөгг нь номын цогцыг зохилдохуй бээр номловой. Түүнчлэнхүү бус бас аль зохисоор цогц төрөн түгэх язгууруудын өөрийн бэлгэ чанарыг сайтар шинжилж хэр хэмээн номлосноо хураатугай”⁹ хэмээн буддын сургаалд аливаа асуудлыг тодорхой зорилго чиглэлтэйгээр авч үзсэн тохиолдолд л тэр нь нэр томъёо, тодорхойлолт, ангилал бүлэг, тоон харьцаанд орохоос бус эгнэгт хөдөлшгүй тодорхойлогдох зүйл байхгүй гэдгийг заасан байна.

Буддын сургаалд авч үздэг нисваанисууд нь сэтгэлийн дотоод гүн мөн чанарыг илрүүлэх саад тотгорууд юм. “Үнэнийг өчүүхэн өчүүхэн бясалгаснаас нисваанисыг тэвчих хэмээн номлосон”¹⁰ нь сэтгэлийн хир, нисваанисуудыг олон төрөл дамжин, олон шаттайгаар дарж устгахыг заасан хэрэг бөгөөд буддын сургаалд сэтгэлийн үзэгдлүүдийг хүний төрөл удмын холбоонд авч үздэг юм. Нөгөө талаар сэтгэлзүйн үзэгдлүүд нь танин мэдэхүйн үйл ажиллагаатай салшгүй холбоотой гэж буддын философид үздэг.

Ясперс ч итгэл үнэмшил, оюун ухаан хоёр эсрэг тэсрэг зүйлс биш, харин уялдаа холбоотой зүйлс гэж үзсэн байдаг. Сэтгэгч хүний сүсэг бишрэл ямагт мэдлэгтэй холбоотой байна. Экзистенц бол ахуй, харин оюун ухаан бол ойлгохуйн эхлэл мөн. Өвчин зовлон, нүгэл хилэнц, тэмцэл мөргөлдөөн зэрэг эмзэг тохиолдолд хүн өөрийн чинад оршихуйгаа, экзистенцээ нээн илрүүлнэ. Харин буддын философийн үзлээр бол хүн сэтгэлийн төвлөрөл, гүн бясалгал бодролоор чинад билигт хүрдэг байна. Гэхдээ Ясперс шашин ба философийн харилцааны асуудлыг тайлбарлахдаа тэдгээрийг эсрэг тэсрэг чанарт авч үзсэн байдаг. “Шашин нь хувилгаан дүр лүү, философи нь зөвхөн хүчин чадал бүхий лавтай үнэн рүү гол төлөв тэмүүлдэг. Шашны хувьд философийн бурхан нь ядмаг дорой, хоосон ядуу мэт төсөөлөгддөг ба шашин нь философийн үзлийг “деизм” хэмээн тоомсоргүйгээр нэрлэдэг, харин философийн хувьд шашны хувилгаан дүр нь хуурамч баг, бурхантай харьцах хуурмаг харьцаа мэтээр төсөөлөгдөнө. Шашин нь философийн бурханыг хоосон хийсвэрлэл хэмээн хочилдог, харин философи нь шашны Бурханы дүрийг уруу татагч зүйл, сүртэй

⁹ Васубанду. Илт номын сангийн үгэнийг бүлэглэсэн. Хэвлэлд бэлтгэсэн М.Гантуяа // Буддын онолын шастарууд. Эрхэлсэн Г. Лувсанцэрэн. УБ. 1999. х.9.

¹⁰ мөн тэнд. х. 34

ч гэсэн бүдүүлэг онгодод бишрэх явдал хэмээн үл итгэдэг байна”¹¹.

Шашны сүсэг бишрэл нь тухайн шашинд сүсэглэгчдийг үл сүсэглэгчдээс нь салган, тэдний хоорондын харилцан ойлголцох боломжийг хаадаг гэж Ясперс үзсэн юм. Харин философийн итгэл үнэмшил нь нийт хүмүүсийн туршлагад тулгуурладаг тул бүхэнд хүртээлтэй болой. Философи нь рационал тайлбарлал өгөх аргагүй асуудлуудыг скептикээр ухамсарлах үүрэгтэй байдаг. Нэг талаас, чинад оршихуйг оюун ухааны эерэг аргуудуудаар баталж болохгүй, иймээс тэр нь итгэл үнэмшил болно, нөгөө талаас, чинад оршихуйн тухай мэдлэгийг оюун ухааны сөрөг аргуудуудаар баталж болно, иймээс тэр нь философи болно. Философийн итгэл үнэмшил нь шашны сүсэг бишрэл ба шинжлэх ухааны мэдлэг хоёрын дунд байдаг, нийт хүн төрөлхтний сүсэг бишрэл болно. “Философийн итгэл үнэмшил нь өөрөө өөрийгөө гэрэлтүүлэхийг хүсдэг. Философидож байгаагаараа би надад тулган хүлээлгэсэн нэг ч зүйлийг түүн рүү нэвтрэхгүйгээр тэр хэвээр нь хүлээж авахгүй. Сүсэг бишрэл бол түгээмэл утгатай мэдлэг болж чадахгүй нь үнэн л дээ, гэхдээ миний итгэл үнэмшлээр дамжиж миний дотор байх болно. Тэгээд зогсолтгүйгээр улам бүр тодорхой, ойлгомжтой болж ухамсрын тусламжаар цааш явах ёстой”¹².

Буддын философид нийт төрөлхтнийг бага, дунд, их хэмээн ангилж, бага төрөлхтний хувьд шашин болж байгаа зүйлийг их төрөлхтөн тогтсон таалал буюу философийн үүднээс авч үздэг тухай сургадаг. Тогтсон тааллыг дотоод ухаанд багтааж шалгадаг ухаан буюу шинжлэх ухааны мэдлэгээс дээгүүрт тавьдаг байна. Ийнхүү буддын сургаалд ердийн ухамсар буюу сүсэг бишрэл, оюун сэтгэлгээ, ухаарахуй, дээд сүсэг-мэдлэг буюу илт онол гэсэн дараалалтай ухамсрыг авч үзнэ.

Энэ мэтчилэн орон зай, цаг хугацааны алслалтай, харилцан шууд залгамж холбоогүй өөр өөр философийн сургаалд авч үзэх асуудлууд нь адил боловч шийдвэрлэх арга зам өөр өөр байгаагаас үйл явцаараа ялгардаг өөр өөр философи сэтгэлгээ, философийн олонлог байдаг болохыг нотолж байна.

¹¹ К.Ясперс. Философи ба шашин // Түүхийн утга учир ба зорилго... (хэсэгчлэл). Орчуулсан М.Гантуяа // Эрх яелөө ба философи. VI. УБ 2000. х.50

¹² К.Ясперс. Философи ба шашин // Түүхийн утга учир ба зорилго... (хэсэгчлэл). Орчуулсан М.Гантуяа // Эрх яелөө ба философи. VI. УБ 2000. х.50

Summary

There are several basic distinctions between Buddhist and modern western philosophy. In this article the philosophy of Karl Jasper is taken for an example of modern western philosophy. Buddhist philosophy is sometimes taken holistic, and has sought as its end some form of enlightenment, while philosophy of K.Jaspers is more concerned with individualism. The arguments are always the same, of course, since every significant thinker puts his own style of expression on the problems they consider. Many of the arguments produced in Buddhist philosophy, for example Four Noble Truths are very different from anything that exists in the philosophy of Jaspers, and often there appears to be an entirely different way of looking at the notion of being and change.